



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/711

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ-ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүрээлэн буй орчны асуудал, шийдэл, гарцуудыг тодорхойлон, эх дэлхийгээ хайрлахад уриалсан “НЭГ ЕРТӨНЦ-НЭГ БОЛОМЖ” сэдвийн хүрээнд “TEDxYouth@Arvaikheer” шилдэг илтгэл тавих арга хэмжээг зохион байгуулах зардалд 1.000.000 (нэг сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1.000.000 (нэг сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101353